



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№201 /411/

2022.11.08

Цаг үе, үйл явдал

Э.ХИШИГДЭЛГЭРИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,422	3,426
EUR	3,410	3,430
CNY	470	473
RUB	52.30	52.70
JPY	23.60	24.00
KRW	2.45	2.49

ЗУРХАЙ

2022.11.08 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 15

**НАМРЫН АДАГ ЦАГААН
НОХОЙ САР
НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ
ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.47-17.24

Барилдлага:

Арвидах

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Мунхрахуй

Египет Улсын Кайр хотод зохион байгуулагдсан Буудлага спортын Дэлхийн аварга шалгаруулах 53 дахь удаагийн тэмцээнд амжилттай оролцож хүрэл медаль хүртсэн Монгол Улсын шигшээ баг, БХЯ-ны "Алдар" спорт хороо, Зэвсэгт хүчний 353 дугаар

ангийн тамирчин ОУХМ, ахлагч Э.Хишигдэлгэрийг Агаарын цэргийн командлалын хамт олон хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Энэ үеэр Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат хамт олон болоод хувиасаа халуун баяр хүргэсний зэрэгцээ булган

сүүлтэй байж араасаа олон шилдэг тамирчныг дагуулах болтугай хэмээн ерөөгөөд дурсгалын зүйлийг талархлын хамт гардуулан өгсөн юм.

Энэ удаагийн Буудлага спортын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд МУГД, дэд хурандаа Л.Ундралбат дасгалжуулагчтай баг

25 метрийн "Center Fire Pistol" буюу том калибрын гар бууны дасгалд эхний 3 байрыг дараалан эзэлсэн нь буудлагын спортын түүхэнд нэг төрөлд Монголын тамирчид тэргүүлсэн гайхамшигт үйл явдал болсон юм.

Ө.НАСАНТОГТОХ

ДЭЛХИЙН ЦОМООС ХОС АЛТАН МЕДАЛЬ ХҮРТЭВ



Сонирхогчдын боксын Дэлхийн цомын тэмцээн энэ сарын 1-5-ны өдрүүдэд ХБНГУ-ын Кельн хотод болж өндөрлөв.

Халлегийн алдарт "Химийн цом" тэмцээн нэрээ өөрчилж энэ жилээс Дэлхийн цом нэртэйгээр зохион байгуулагдаж байна.

Герман Улсын Кельн хотын рингд манай улсаас 9 боксчин өрсөлдсөнөөс, "Алдар" спорт хорооны МУГД, хошууч А.Гантулга, ОУХМ, ахлах дэслэгч Ж.Отгонбаяр дасгалжуулагчтай 5 тамирчин оролцож 2 алт, 1 мөнгө, 2 хүрэл, нийт 5 медаль хүртлээ.

Эмэгтэйчүүдийн 57 кг-ийн жинд ОУХМ, дэд ахлагч М.Энхжаргал, 60 кг-ийн жинд ОУХМ Г.Бадмаараг нар Дэлхийн цомын аварга болж эмэгтэй боксчдоос түүхэн амжилт үзүүлэв.

Тодруулбал, эмэгтэйчүүдийн 57 кг-ийн жинд

М.Энхжаргал, -60 кг-ийн жинд Г.Бадмаараг нар алт, -50 кг-ийн жинд Н.Оюун-Эрдэнэ хүрэл, эрэгтэйчүүдийн -57 кг-ийн жинд Х.Энх-Амар мөнгө, -60 кг-ийн жинд О.Тулга хүрэл медалийг тус тус хүртсэн юм.

АЛДАР СПОРТ ХОРОО



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 638,070,832

Эдгэрсэн

Нийт: 617,932,363

Нас барсан

Нийт: 6,607,055

Цаг үе, үйл явдал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 337 ДУГААР АНГИД...



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны зарим байцаагч болон АЦК-ын ахлах мэргэжилтэн хурандаа С.Дашдондог нар Зэвсэгт хүчний 337 дугаар ангид ажиллалаа.

Энэ хүрээнд замын хөдөлгөөний дүрмийн сургалтыг ангийн бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулсаны зэрэгцээ ангид тулгамдаж буй асуудлын талаар ангийн удирдлага болон автын мэргэжилтнүүдтэй

санал бодлоо солилцсон юм.

Мөн өвлийн улирал болж, замын халтиргаа гулгаа эхэлж байгаатай холбогдуулан Налайх дүүргийн Тээврийн цагдаагийн албаны байцаагч, зохицуулагч дэслэгч Б.Сүхбатыг урьж, ангийн нийт бүрэлдэхүүнд зам тээврийн хууль, дүрэм, аюулгүй байдлын талаар сургалтыг зохион байгууллаа.

ТЭСВЭР, ТЭВЧЭЭР, БАГИЙН АМЖИЛТ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

"Тэсвэр, тэвчээр, багийн амжилт" сэдэвт туухай өргөлтийн тэмцээн нийт 6 баг буюу хугацаат цэргийн 36 алба хаагч оролцож 60, 65, 70, 75, 80, +85 кг-ийн төрөлд хүрд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Тэмцээний тэргүүн байрт дэслэгч Б.Алтайхүү салааны захирагчтай II мотобуудлагын ротын II салааны баг тамирчид, дэд байрт дэслэгч Ж.Дашмягмар салааны захирагчтай II мотобуудлагын ротын I салааны баг тамирчид тус тус шалгарлаа.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 325 ДУГААР АНГИД...



2022-2023 оны сургуулийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан ангийн захирагч хурандаа Б.Баярсайханы санаачилгаар "Бие бүрэлдэхүүндээ талархъя" талархлын аяныг өрнүүлж байна. Аяны хүрээнд талархлын самбарыг байршуулсан бөгөөд агаарын дархан хилийг сахин хамгаалах ариун үйлсэд оюун ухаан, бие сэтгэлээ зориулж буй нийт офицер, ахлагч, ажилчин албан хаагчид талархсан сэтгэлээ илэрхийлсээр байгаа юм.

2022-2023 оны сургуулийн жилийн нээлтийг тохиолдуулан тус ангийн "Хорооны командын байр"-ын бие бүрэлдэхүүний дунд "Цол бүхэн сайхан" гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж явууллаа.

Тус тэмцээнд 10 баг хурд хүч, ур чадвараа сорин өрсөлдсөнөөс дэд ахлагч Т.Билэгсайхан ахлагчтай баг тамирчид алтан медаль, шилжин явах цомын эзэд болов. Харин дэд хурандаа Э.Энхбаяр ахлагчтай удирдлагын баг

дэд байрт, ахлах ахлагч Ж.Жамъяндорж ахлагчтай ахлах ахлагч нарын баг гутгаар байрт тус тус шалгарлаа.

Б.ХАТАНБААТАР

МОРЬТОН ДАЙЧИД ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТЭЭР



Зэвсэгт хүчний 232 дугаар анги

Морьтон дайчид хичээлийн шинэ жилийн нээлтийг тохиолдуулан дадлагын дохиогоор ажиллаж, тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор 5 км-ийн маршийг үйлдлээ.

Марш үйлдэх үед өгөгдсөн цагийн байдлын дагуу бие бүрэлдэхүүнийг ажиллуулсаны зэрэгцээ аранзны иж бүрдэл, хамгаалах хэрэгсэлд үзлэг явуулж ололттой болон дутагдалтай талуудыг акт, нотломжид тусгаж ажиллалаа.


Мөн офицер, ахлагч нарын "Заах арга зүйн" цугларалтыг "Өөрчлөлтийг өөрөөсөө" сэдвийн хүрээнд зохион байгуулж ангийн захирагч хурандаа Н.Мягмарцоож "Байгууллагын соёл, удирдагчийн манлайлал", ангийн ахлагч сургагч ахлагч Н.Лхагвацэрэн "Зэвсэгт хүчний ахлагч нарын сургалт, бэлтгэлийн өнөөгийн байдал" сэдвээр тус тус сургалт, хэлэлцүүлгийг өрнүүллээ.

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №19

7 ЭГШГИЙГ УНШИХ, БИЧИХ /үргэлжлэл/

Бид, монгол хэлнийхээ 7 богино эгшгийг монгол бичигт хэрхэн тэмдэглэдгийг "7 титмийн" буюу хөндлөн бичиглэлийн аргачлалаар үзэж судаллаа. Нэгтгэж үзвэл, дармал тигээр:



Бичмэл тигээр:



Эрхэм уншигч та, төгсгөлд ордог А, Э, И, О, У, Ө, Ү гэж аялгуулан дуудаж, бүтэц зурлагын нь хувирлын дагуу зөв, цэвэрхэн бичиж сураарай.



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)